| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 15,348,900.00           | 15,348,900.00               | -                       | <b>100.00</b> |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 3,837,200.00            | 3,837,200.00                | -                       | <b>100.00</b> |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 38,372,400.00           | 38,372,400.00               | -                       | <b>100.00</b> |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                | <b>286,676,300.00</b>   | <b>286,441,745.00</b>       | <b>(234,555.00)</b>     | <b>99.92</b>  |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 259,250,000.00          | 259,015,445.00              | <b>(234,555.00)</b>     | <b>99.91</b>  |
| 210302      | Түлш, халаалт   | 22,739,000.00           | 22,883,964.00               | <b>144,964.00</b>       | <b>100.64</b> |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 2,767,300.00            | 4,122,336.00                | <b>1,355,036.00</b>     | <b>148.97</b> |
| 210304      | Байрны түрээс   | 1,920,000.00            | 420,000.00                  | <b>(1,500,000.00)</b>   | <b>21.88</b>  |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | <b>347,146,900.00</b>   | <b>347,146,899.90</b>       | <b>(0.10)</b>           | <b>100.00</b> |
| 210401      | Бичиг хэрэг   | 8,283,600.00            | 5,879,000.00                | <b>(2,404,600.00)</b>   | <b>70.97</b>  |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 281,463,300.00          | 286,955,531.90              | <b>5,492,231.90</b>     | <b>101.95</b> |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                              | 2,400,000.00            | 2,819,332.00                | <b>419,332.00</b>       | <b>117.47</b> |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал       | 37,500,000.00           | 37,500,000.00               | -                       | <b>100.00</b> |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                     | 17,500,000.00           | 13,993,036.00               | <b>(3,506,964.00)</b>   | <b>79.96</b>  |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | <b>65,456,000.00</b>    | <b>65,456,000.00</b>        | -                       | <b>100.00</b> |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                     | 65,456,000.00           | 65,456,000.00               | -                       | <b>100.00</b> |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | <b>103,000,000.00</b>   | <b>103,000,000.00</b>       | -                       | <b>100.00</b> |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                                    | 13,000,000.00           | 13,000,000.00               | -                       | <b>100.00</b> |
| 210604      | Урсгал засвар   | 90,000,000.00           | 90,000,000.00               | -                       | <b>100.00</b> |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                   | <b>1,480,000.00</b>     | <b>430,000.00</b>           | <b>(1,050,000.00)</b>   | <b>29.05</b>  |
| 210702      | Дотоод албан томилолт   | 1,480,000.00            | 430,000.00                  | <b>(1,050,000.00)</b>   | <b>29.05</b>  |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>150,873,800.00</b>   | <b>148,448,978.00</b>       | <b>(2,424,822.00)</b>   | <b>98.39</b>  |

Дархан-Уул аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|             |  |                         |                         |                        |               |
|-------------|--|-------------------------|-------------------------|------------------------|---------------|
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 114,551,300.00          | 114,551,300.00          | -                      | 100.00        |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 2,000,000.00            | 2,000,000.00            | -                      | 100.00        |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 9,402,700.00            | 9,402,700.00            | -                      | 100.00        |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 2,310,100.00            | 2,310,000.00            | (100.00)               | 100.00        |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 990,000.00              | 924,500.00              | (65,500.00)            | 93.38         |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 9,425,700.00            | 9,425,700.00            | -                      | 100.00        |
| 210807      | Газрын төлбөр  | 12,194,000.00           | 9,834,778.00            | (2,359,222.00)         | 80.65         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>123,523,500.00</b>   | <b>123,523,099.85</b>   | <b>(400.15)</b>        | <b>100.00</b> |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 123,523,500.00          | 123,523,099.85          | (400.15)               | 100.00        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>96,605,000.00</b>    | <b>93,268,126.00</b>    | <b>(3,336,874.00)</b>  | <b>96.55</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>96,605,000.00</b>    | <b>93,268,126.00</b>    | <b>(3,336,874.00)</b>  | <b>96.55</b>  |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 88,205,000.00           | 84,874,009.00           | (3,330,991.00)         | 96.22         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 8,400,000.00            | 8,394,117.00            | (5,883.00)             | 99.93         |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>3,311,461,100.00</b> | <b>3,217,533,515.75</b> | <b>(93,927,584.25)</b> | <b>97.16</b>  |
| <b>32</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>3,311,461,100.00</b> | <b>3,217,533,515.75</b> | <b>(93,927,584.25)</b> | <b>97.16</b>  |
| 320001      | Орон нутгийн төсвөөс   | 2,602,370,300.00        | 2,508,442,715.75        | (93,927,584.25)        | 96.39         |
| 320002      | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                              | 709,090,800.00          | 709,090,800.00          | -                      | 100.00        |
| <b>6</b>    | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                              | <b>491.00</b>           | <b>491.00</b>           | <b>-</b>               | <b>100.00</b> |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>  | <b>1.00</b>             | <b>1.00</b>             | <b>-</b>               | <b>100.00</b> |
| 610001      | Төсвийн байгууллага  | 1.00                    | 1.00                    | -                      | 100.00        |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>  | <b>245.00</b>           | <b>245.00</b>           | <b>-</b>               | <b>100.00</b> |
| 620001      | Удирдах ажилтан  | 1.00                    | 1.00                    | -                      | 100.00        |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан  | 8.00                    | 8.00                    | -                      | 100.00        |
| 620003      | Үйлчлэх ажилтан  | 236.00                  | 236.00                  | -                      | 100.00        |
| <b>65</b>   | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>   | <b>245.00</b>           | <b>245.00</b>           | <b>-</b>               | <b>100.00</b> |
| 650009      | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                           | 245.00                  | 245.00                  | -                      | 100.00        |

*Пийк-Ом Аудит ХХК*

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуухсвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он    | Гүйцэтгэл            |
|-------------|--|-------------|----------------------|
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   | 0.00        | 0.00                 |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>0.00</b> | <b>30,777,516.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>0.00</b> | <b>30,777,516.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>0.00</b> | <b>30,777,516.00</b> |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>0.00</b> | <b>386,400.00</b>    |
| 210402      | Тээвэр, шатахуун   | <b>0.00</b> | 386,400.00           |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>0.00</b> | <b>30,391,116.00</b> |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | <b>0.00</b> | 30,391,116.00        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>0.00</b> | <b>30,777,516.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>0.00</b> | <b>30,777,516.00</b> |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | <b>0.00</b> | 24,345,900.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 0.00        | 6,431,616.00         |
| 131106      | Төсвийн урамшуулал   | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>  | <b>0.00</b> | <b>0.00</b>          |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   | 0.00        | <b>0.00</b>          |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | <b>0.00</b> | <b>0.00</b>          |

Пийк-Ом Аудит ХХК

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, тоног төхөөрөмж, хөрөнгүүдийг цаг тухайн бүрт бүртгэн санхүүгийн тайланд тусган ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Б.Жаргалсайхан, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Пийк-Ом Аудит” ХХК-ны чанарын хяналтын менежер Б. Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-нд 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийтийн аж ахуй үйлчилгээний газар нь “Эрүүл аюулгүй эко цэвэр орчин бүрдүүлэх замаар иргэдийн нийтлэг эрх ашгийг хангасан бодит гүйцэтгэлээр тэргүүлэгч мэргэшсэн үйлчилгээний байгууллага болох” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус төвийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,630,532.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 46,305.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 32,413.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дархан-Уул аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,326,929.2 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөг/ |
|--|----------------|-----------------|-----------------|
|  |                |                 | Өөрчлөлт        |
| Б  | 1              | 2               | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                             | -              | -               | -               |
| Авлага                                     | 6,431.6        | -               | (6,431.6)       |
| Бараа материал                             | 550,681.3      | 817,921.8       | 267,240.5       |
| Үндсэн хөрөнгө                             | 41,373,402.8   | 42,439,523.1    | 1,066,120.3     |
| Нийт хөрөнгө                               | 41,930,515.7   | 43,257,444.9    | 1,326,929.2     |
| Өр төлбөр                                  | -              | 5,000.0         | 5,000.0         |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/        | 41,930,515.7   | 43,252,444.9    | 1,321,929.2     |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 41,930,515.7   | 43,257,444.9    | 1,326,929.2     |

Авлагын дансны хувьд өмнөх онд үүссэн байгууллагаас авах 6,431.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна

Бараа материал дансны үлдэгдэл 267,240.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 619,769.9 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгийн газар, Дархан сумын хөрөнгө оруулалтаар хийгдэх Дархан 50 цогцолборын засварын материал 46,593.2 мянга, Жишиг хорооллын засварын материал 91,172.8 мянга, гудамжны гэрэлтүүлгийн материал 142,842.8 мянга, бусад хувь хүн байгууллагаас 45,243.4 мянга, нийт 325,852.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, аж ахуй иргэдээс 9,943.6 мянган төгрөгийн аж ахуйн материалыг хандиваар авч, 660,890.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ. Өмнөх оноос аж ахуй, барилгын материалын үлдэгдэл өндөр байгаа нь Дархан сумын хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2021 онд хийгдэхээр төлөвлөсөн ажлуудын худалдан авах ажиллагаа оны эцэст хийгдэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд тайлант онд 7,138.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, аж ахуй нэгж болон иргэдээс нийт 138,495.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Дархан уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолуудыг үндэслэн хандиваар, Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын даргын 2022 оны 2 дугаар сарын 01 өдрийн 48 тоот албан бичгийг үндэслэн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,942,994.3 мянган төгрөгийн тохижилт, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслүүдийг үндсэн хөрөнгийн холбогдох дансуудад бүртгэн авч, ашиглалтын хугацаа дуусч цаашид ашиглах боломжгүй болсон 197,278.1 мянган төгрөгийн хөрөнгийг Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 12 сарын 31-ны өдрийн 01-01А/398 тоот захирамжаар актлаж, 1,942,184.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулан, үндсэн хөрөнгө актлахтай холбоотой хуримтлагдсан элэгдэл, дахин үнэлгээний нэмэгдэл дансыг 116,955.2 мянган төгрөгөөр залруулга бичилт хийн оны эцэст 42,439,523.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 43,257,444.9 мянган төгрөг болж 1,321,929.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 981,671.4 мянган төгрөгөөр буюу 17 хувиар нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн санхүүжилт 320,343.2 мянга, дээд

шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 19,345.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 651,540.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 365,457.7 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хангамж, бараа материалын зардал 86,725.4 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 59,651.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 76,209.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 47,887.5 мянган төгрөгөөр тус тус өсч, үндсэн хөрөнгийн элэгдэл, төвлөрүүлэх шилжүүлгийн зардлууд голлон нөлөөлжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 3,643,730.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 332,269.8 мянган төгрөгөөр бууруулж, 3,311,461.1 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 1,807,726.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,494,569.9 мянган төгрөгөөр төсөвлөсөн нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 133,887.4 мянга, тайлант оны батлагдсан төсвөөс 9,164.8 мянган төгрөгөөр тус тус өндөр батлагдсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,311,461.1 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 2,602,370.3 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 709,090.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,602,370.3 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 709,090.8 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 505.0 мянга нийт 3,311,966.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,217,533.5 мянган төгрөгийг зарцуулж, 93,927.5 мянган төгрөгийг орон нутгийн санд төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,217,533.5 мянган төгрөг буюу 97.16 хувьтай байна. 2021 онд материаллаг түвшингээс дээш хэмнэгдсэн зардал нь төлөвлөсөн орон тоогоор ажилаагүйгээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардал 86,880.9 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 30,777.5 мянган төгрөг орж ирсэнээс тээвэр шатахууны зардалд 386.4 мянга, хангамж, бараа үйлчилгээний бусад зардалд 30,391.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Дархан -Уул аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохиох 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 129 мэдээлэл, 179,325.7 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар Газрын даргын 2020 оны А/01 тоот тушаалын хавсралтаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох хувь хэмжээг хоёр өөр хувь хэмжээгээр тооцож зөрүүтэй тушаал шийдвэр гаргасан, шилэн дансанд мэдээлэл 19 мэдээлэл оруулаагүй байсан. Биелэлтийг 2021 оны 12 сарын 03-ны өдрийн 436 тоот албан бичигээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 50 хувьтай ба шилэн дансны мэдээллийг 20 удаа хоцроож мэдээлсэн байна..

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд орлого авсан үндсэн хөрөнгийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолтой тулган баталгаажуулах хэрэгтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,589,246.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 3,392,000.1 мянган төгрөгийн 6 алдаа залруулж, 197,246.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, цаашид анхааран ажиллах 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

- Орон нутгийн хөрөнгө оруулалт, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бие болсон 2,942,994.3 мянган төгрөгийн хөрөнгийг орлого аваагүйг
- Гүйцэтгэл бүрэн гараагүй 5,000.0 мянган төгрөгийн ажлыг тайлант хугацаанд зардалд тусгасан, өглөгөөр бүртгэх
- Балансын дансанд бүртгэлтэй хасах утгатай 8 нэр төрлийн 953.3 мянган төгрөгийн хөрөнгийг залруулж бүртгэх
- Тээвэр шатахууны зардлыг үр дүнгийн тайланд 433.1 мянган төгрөгөөр дутуу тусгасан
- Туслах үйл ажиллагаанаас орсон 505.0 мянган төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй
- Тайлант оны элэгдэлийг 442,114.4 мянган төгрөгөөр дутуу байгуулсаныг дахин тооцуулан зардалд тусган залруулсан.

#### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.3 Албан шаардлага

##### 1. Гэрээ, гэрээний хэрэгжилт, зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Сод монгол групп ХХК-тай 2020.05.27-нд байгуулсан гэрээний хугацаа дуусаж, 2021.05.27-нд гэрээ сунгах нэмэлт гэрээ хийхдээ өмнөх байгуулсан гэрээний нэгэн адил хүчинтэй байна гэж заасан. 2021 оны 6 дугаар сараас хойш шатахууны нэгж үнэнд өөрчилөлт орсон талаар харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчилөлт оруулалгүйгээс шатахууны үнийн зөрүү гэж 12,920.4 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд шууд тусган шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийн 40.4-д "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд..... үнэд захиалагч тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Шийдвэрлэсэн: Цаашид алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

##### 2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан 179,325.7 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

2.2. Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

##### 3. Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөрийн тооцоог хянан баталгаажуулаагүйгээс 5,000.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар болон, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бие болсон хөрөнгийг цаг тухайн бүрт орлого аваагүй, тайлан тооцоог Орон нутгийн өмчийн газартай тулган баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд засвар, залруулга олон удаа орж санхүүгийн тайлан баталгаажуулах хугацаа хоцроосон.

1.2. Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, тоног төхөөрөмж, хөрөнгүүдийг цаг тухайн бүрт бүртгэн санхүүгийн тайланд тусган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

| д/<br>д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр                   | Нийт алдаа, зөрчлийн |             | Үүнээс    |             |               |     |                 |           |         |     |
|---------|---|----------------------|-------------|-----------|-------------|---------------|-----|-----------------|-----------|---------|-----|
|         |   |                      |             | Залруулга |             | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |           | Зөвлөмж |     |
|         |   | Тоо                  | Дүн         | Тоо       | Дүн         | Тоо           | Дүн | Тоо             | Дүн       | Тоо     | Дүн |
| 1       | Дархан-Уул аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газар | 10                   | 3,589,246.2 | 6         | 3,392,000.1 | 0             | 0   | 3               | 197,246.1 | 1       | 0   |
|         | Дүн   | 10                   | 3,683,173.8 | 7         | 3,485,927.7 | 0             | 0   | 3               | 197,246.1 | 1       | 0   |

ПИЙК-ОМ АУДИТ ХХК

2022.02.25

